



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот


Гадны иргэдийг нэвтрүүлэх  
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, 8.4 дэх хэсэг, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь заалт, 12.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газарт "Гадны иргэдийг нэвтрүүлэх журам", зочны үнэмлэхний загварыг тус тус хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /Б.Алтансүх/-т үүрэг болгосугай.


ДАРГА



Ц.ЖАДАМБАА

111327

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
газрын даргын 2014 оны 108 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## ГАДНЫ ИРГЭДИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ 5202965

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар /цаашид газар гэх/-ын байранд гадны иргэдийг зохих зөвшөөрлийн дагуу нэвтрүүлэх, байгууллагын дотоод дэг журмыг хэрэгжүүлэхэд оршино.

1.2 Газарт албан ажлаар болон хувийн шалтгаанаар нэвтэрсэн гадны иргэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### Хоёр. Газарт нэвтрэх баримт бичиг

2.1 Гадны иргэд иргэний үнэмлэх болон ажлын үнэмлэхийг үндэслэн олгосон зочны үнэмлэхээр тус газарт нэвтэрнэ.

2.2 Зочны үнэмлэхийг жижүүрээс олгох ба үнэмлэх олгосон бүртгэлийг хөтөлсөн байна.

2.3 Газарт тодорхой хугацаагаар ажиллах ажилтан болон оюутнуудыг Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас жижүүрт урьдчилан өгсөн нэрсийг үндэслэн нэвтрүүлнэ.

2.4 Газарт зохион байгуулагдах сургалт семинар, хурал, уулзалтанд оролцох хүмүүсийн нэрсийг тухайн арга хэмжээг хариуцан зохион байгуулж байгаа газар, хэлтсийн албан тушаалтан жижүүрт 1-ээс доошгүй хоногийн өмнө өгч оролцогчдыг зочны үнэмлэхгүйгээр нэвтрүүлнэ.

### Гурав. Шалган нэвтрүүлэх

3.1 Гадны иргэдийг зөвхөн төв хаалга /Чингисийн талбай руу харсан хаалга/-аар нэвтрүүлнэ.

3.2 Жижүүр нь ажлын өдөр, ажлын цагаар байрны төв хаалганаас гадна бусад хаалгаар орж гарч байгаа хүмүүсийг теле хяналтын камерын дэлгэцээр хянаж байх ба шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед болон баяр, амралтын өдөр, ажлын бус цагаар биечлэн шалгаж байна.

3.3 Түр нэвтэрсэн иргэдэд зөвхөн уулзах албан хаагчтайгаа уулзаад гарах, объектын бусад хэсгээр сэлгүүцэхгүй байхыг сануулж, жижүүр нь теле хяналтын камерын дэлгэцээр хяналт тавина.

3.4 Газарт архи согтууруулах ундааны зүйл оруулахыг хориглох ба архи согтууруулах ундаа хэрэглэсэн хүнийг нэвтрүүлэхийг хориглоно.

### Дөрөв. Жижүүрийн хүлээх үүрэг

4.1 Газарт нэвтэрч байгаа гадны иргэдийн баримт бичгийг заавал шалгаж нэвтрүүлнэ.

4.2 Гадны иргэдийг газарт нэвтрүүлэхдээ иргэний үнэмлэх болон ажлын үнэмлэхийг үндэслэн бүртгэл хөтөлж, зочны үнэмлэх олгон, гарахад нь буцаан авч байна.

4.3 Жижүүр нь газарт нэвтэрч байгаа хүмүүстэй соёлтой харьцана.

4.4 Баяр, амралтын өдөр болон ажил тарсаны дараа нийт өрөө тасалгаа, коридорын цоож, тог цахилгааныг шалгаж байна.

#### Тав. Хориглох зүйлс

5.1 Баяр, амралтын өдрүүд болон ажлын бус цагаар удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүй иргэнийг нэвтрүүлэх.

5.2 Газарт 16-аас доош насны хүүхдийг /тусгай арга хэмжээнд уригдсанаас бусад үед/ асран хамгаалагчгүй оруулах.

5.3 Гадны иргэдийг зочны үнэмлэхгүйгээр нэвтрүүлэх.

5.4 Албаны зориулалттай компьютер, тоног төхөөрөмж, тавилга, эд зүйлсийг хариуцсан газрын даргын зөвшөөрөлгүй гадагш авч гарах.

5.5 Газрын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн иргэнийг нэвтрүүлэх.

5.6 Газрын албан хаагчдын цайны газарт гадны иргэдийг нэвтрүүлэх.


#### Зургаа. Бусад зүйл

6.1 Жижүүр нь шалган нэвтрүүлэх ажиллагааг энэхүү журмын дагуу явуулж байгаа эсэхэд газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар хяналт тавина.

6.2 Жижүүр албан үүргээ гүйцэтгэх үедээ энэхүү журмыг зөрчсөн нь тогтоогдвол Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

\_\_\_\_\_ о О о \_\_\_\_\_

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
газрын даргын 2014 оны . . сарын . . өдрийн  
. . . дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ЗОЧНЫ ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

### 1. Урд тал



### 2. Ар тал

